

БАТЛАВ:  
СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН  
ДЭД БҮТЦИЙН ХӨГЖЛИЙН АЛБА  
ОНӨААТҮГ  
ЗАХИРАЛ... Ж.МӨНХЗОРИГ

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

2024 оны 03 дугаар сарын 04-ний өдөр

Улаанбаатар хот

**Барааны тодорхойлолт:** АИ-92 автобензин, Дизель түлш нь чанарын шаардлага хангасан, олон улсын стандартад нийцсэн, улирлын шинжтэй байх. Монгол улсын MNS 0217 - 2006 7х "Дотоод шаталтат хөдөлгүүрийн түлш: Автобензин" стандарт, илчит тэрэг болон хөлөг онгоцны болон хурдан эргэлттэй дизель хөдөлгүүр, хийн турбинт хөдөлгүүрт зориулсан газрын тосны бүтээгдхүүнд хамаарах Монгол улсын MNS 216 - 2006 7х "Дизелийн түлш" стандартад дүйцэх буюу түүнээс илүү бол хүлээн зөвшөөрөх тул уг стандартыг хангаж буйг нотлох бичиг баримтыг заавал ирүүлнэ. Тус байгууллага нь үер ус, халиа дошин зэрэг гэнэтийн, цаг хугацаа хамаардаггүй учир тухай бүрт нь шатахуун, түлшийг саадгүй олгож байх шаардлагатай. Мөн байнгын шатахуун, түлш бэлэн байх хэрэгтэй.

№	Барааны нэр төрөл	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1.	АИ-92 бензин	литр	7.200	2,200	15,840,000
2.	Дизель түлш	литр	41.500	3,400	141,100,000

1. Стандарт: Монгол улсад мөрдөж буй стандарт, олон улсын стандартад нийцсэн бараа байна. Тендерт оролцогч нь Стандарчлал хэмжил зүйн баталгаатай түгээгүүртэй байна.

2. Баглаа, боодол: Барааг тээвэрлэх, хадгалах үеийн баглаа, боодлыг нийлүүлэгч бүрэн хариуцна. Шатахууныг стандарт хангасан зориулалтын савнаас нийлүүлэлт хийнэ.

3. Барааг хүргэх газар: Шатахуун түгээх станцаар дамжуулан шатахуун олгох зөвшөөрлийн дагуу жолоочид олгоно.

4. Бусад: Зах зээл дээр шатахууны хомсдол үүссэн үед гэрээт байгууллагын хэрэгцээг зохих түвшинд хангах шатахууны нөөцтэй байх

БОЛОВСРУУЛСАН:  
ЗАХИРГАА УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА



П.ПҮРЭВСҮРЭН